**“БОЛДГЯНТБОЛД” ХХК-ИЙН (ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЕСӨНБУЛАГ СУМ) ДУГУЙ НЭРТЭЙ ТАЛБАЙН ЗҮҮН САЙРЫН АЛТНЫ ШОРООН ОРДЫГ АШИГЛАХ**

2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНЫ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

**/ МУ- 021169, РД 5884098/**

2025

## Ерөнхий мэдээлэл

Болд гянт болд ХХК-ний ашиглалтын талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт орших ба Улаанбаатар хотоос баруун зүгт 1000 км, Алтай хотоос зүүн урагш 65 км, Наран багийн төвөөс зүүн тийш 16 км зайд тус тус алслагдсан, зам харилцаа дэд бүтэц харьцангуй сайн районд хамаарна.

**Зураг 1 Төслийн талбайн байрзүйн зураг**




**Хүснэгт 1 Төслийн талбайн сольбилцол**

| № | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Градус | Минут | Секунд | Градус | Минут | Секунд |
| 1 | 96 | 40 | 40.19 | 46 | 4 | 43.47 |
| 2 | 96 | 45 | 0.18 | 46 | 3 | 53.5 |
| 3 | 96 | 45 | 0.18 | 46 | 3 | 28 |
| 4 | 96 | 44 | 35 | 46 | 3 | 28 |
| 5 | 96 | 44 | 35 | 46 | 3 | 45 |
| 6 | 96 | 43 | 4 | 46 | 3 | 45 |
| 7 | 96 | 43 | 4 | 46 | 4 | 6 |
| 8 | 96 | 41 | 31 | 46 | 4 | 6 |
| 9 | 96 | 41 | 31 | 46 | 4 | 24 |
| 10 | 96 | 40 | 7.42 | 46 | 4 | 24 |
| 11 | 96 | 40 | 7.42 | 46 | 4 | 40.8 |
| 12 | 96 | 40 | 40.19 | 46 | 4 | 43.47 |

## Уурхайн ажиллах горим ба ашиглалтын хугацаа

Ордын хөрс хуулалт дунджаар 6.8м, алт агуулсан элсний зузаан нь дунджаар 1.5 м, хэвтээ байрлалтай нэг давхаргатай нэлээд урт. Орд нь дунд зэргийн агуулгатай, байгалийн болон уул техникийн хүндрэл харьцангуй бага.

Дээрх уул техникийн нөхцөл, ажлын даалгаврыг үндэслэн ордыг ил уурхайн аргаар авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглахаар төсөлд тусгасны дагуу.

Ордын тогтцоос хамааран хөрсийг гадаад болон дотоод овоолгод тээвэрлэн түр овоолго үүсгэлээ.

***Хүснэгт 2 Ашиглалтын технологийн схем***

<table>
<tr><th>Ашиглалтынсистем</th><th>Үндсэн ажил</th><th>Технологийн процесс</th></tr>
<tr><td rowspan="4">Автотээвэртэй ашиглалтын систем</td><td rowspan="2">Хөрсхуулалт</td><td>Ухаж ачих</td></tr>
<tr><td>Тээвэрлэх(Гадаад баДотоод овоолго)</td></tr>
<tr><td rowspan="2">Элсолборлолт</td><td>Ухаж ачих</td></tr>
<tr><td>Тээвэрлэх(Угаахүйлдвэр)</td></tr>
</table>

## Замын тоос дарсан ажил

Орон нутгийн уур амьсгал, замын хөдөлгөөний эрчим, тухайн үйл ажиллагааны байдлаас хамааран замын тоос дарах ажлыг 5-9 сар буюу замын тоосжилтын дулааны улиралд өдөрт 1 удаа зам талбайг тогтмол усаллаа.

## Баяжуулах технологи

Дугуй нэртэй алтны шороон ордыг ашиглах энэхүү төсөлд алт агуулсан элсний найрлага, шинж чанар, технологийн туршилт судалгааны үр дүнд үндэслэн шороон ордын элсийг гравитацийн аргаар баяжууллаа.

Төслийн тус бүлэгт шороон ордын элсний технологийн тооцоо, бүтээгдэхүүн гаргалт, усны хэрэглээ, угаан баяжуулах цехийн тоног төхөөрөмж, цехийн ерөнхий төлөвлөлт, тунаах болон цэвэр усны далангийн ерөнхий төлөвлөлтийг дагуу байгуулсан.

Ашиглалтын үйл ажиллагаа явуулсан нийт хугацаанд уурхайгаас 11,930 $м^3$ элс нийлүүлсэн бөгөөд баяжуулалтад ачаалах элсний дундаж агуулга 99.92 мг/$м^3$ байна.

## Элс баяжуулах технологийн горим, схем, балансын тооцоо

Ордын ашиглалтын нөөцөд тулгуурлан алт агуулсан элсийг 3 жилийн хугацаанд угаан баяжуулахаар тооцоолсон бөгөөд ил уурхайгаас олборлосон алттай элсийг гравитацийн аргаар баяжуулан угаах төхөөрөмж бүхий үйлдвэрийг ил уурхайн дэргэд байрлуулах юм.

Ил уурхайгаас олборлосон элсийг автосамосвалаар тээвэрлэн угаан баяжуулах цехийн тэжээлийн талбайд буулгана. Тэжээлийн талбай дахь алт агуулсан элсийг утгуурт ачигчаар скрубберийн бункерт ачааллана. Скруббер буюу угаан ангилах төхөөрөмж нь элсийг +30 мм-ийн хүрдэн шүүрээр шигшиж, угаан ангилна

Скруббер – бутар буюу угаан ангилах төхөөрөмж нь элсийг +30мм, -30+10мм, -10мм гэсэн 3 ангилалд хуваана. +30мм болон -30+10мм –ийн ангиллыг галийн овоолгод хураах бөгөөд -10мм –ийн ангиллын элсийг цаашид гүн дүүргэлт, нам дүүргэлтийн шлюзээр баяжуулна. Шлюзийн баяжмалыг сэгсрэх ширээгээр баяжуулах бөгөөд металл авалт 96% байхаар тооцоолсон. Гүн болон нам дүүргэлтийн шлюзийн баяжмалыг ээлжиндээ 1-2 удаа /4-8цаг тутамд/ авна.

**Технологийн ус эргүүлэн ашиглалт**: Угаах төхөөрөмжүүдийн шлюзийн хаягдал өөрийн урсгалаар тунгаах далан руу орж хуримтлагдана. Тунгаах даланд тунасан усыг газрын хэвгий ашиглан өөрийн урсгалаар нь цэвэршүүлэх даланд оруулж шүүгдсэн усыг технологийн эргэлтийн усаар буцаан ашиглана.

## Угаан баяжуулах технологийн тооцоо

Алт агуулсан элсийг баяжуулах үйлдвэрийн технологийн тооцоог хийхдээ "Геологийн Төв Алт агуулсан элсийг баяжуулах үйлдвэрийн технологийн  тооцоог хийхдээ Экологи-Технологийн судалгааны “ВИСМУТИН” ХХК-ийн боловсруулсан технологи туршилтын тайланг үндэслэн бүтээгдэхүүний тоо-чанар, ус-шлам болон усны балансын тооцоог гүйцэтгэсэн. Алт агуулсан элсийг угаан баяжуулах үйлдвэрийн тоо- чанарын тооцоогоор үйлдвэрийн хүчин чадал, технологийн шат дамжлага бүр дэх алтны агуулга, гарц зэргийг тодорхойлсон. Ус-шламын тооцоогоор технологийн шат дамжлага, тоног төхөөрөмж бүр дэх усны болон булингын хэмжээ, бүтээгдэхүүний хатуулаг зэргийг тооцсон. Усны балансын тооцоогоор баяжуулах үйлдвэрийн технологид орсон, гарсан усны балансыг тооцож, баяжуулах үйлдвэрт шаардлагатай усны хэмжээ болон 1 тн элс угаан баяжуулахад шаардагдах усны зарцуулалтыг тооцсон.

## Хаягдлын сан

Уурхайн хаягдлын усан сан нь ашиглагдаж дууссан орон зай дотор байгуулагдах учир сэтрэх, ус алдагдах зэрэг хүндрэлүүд гарахгүй. Хаягдлын усан сангийн эзлэхүүнийг тооцохдоо угаан баяжуулах цехийн үйл ажиллагааг тасралтгүй 2 хоног хангах боломжийг бүрдүүлэхээр төлөвлөсөн. $V_{усан\,сан} = W_{ус} * 2 = 4{,}985 * 2 = 9{,}970$ м$^3$, цэвэр усны хоногийн хэрэглээ нь 997 м$^3$ бөгөөд цэвэр усны сангийн багтаамж нь $V_{цэвэр\,ус} = W_{цэвэрус} * 2 = 997 * 2 = 1{,}994 \approx 2{,}000$ м$^3$–ээс багагүй байх шаардлагатай.




***Зураг 2 Хаягдлын нуур***

## Ус ашиглах зориулалт:

Алтны шороон ордыг ашиглах явцад дараах 3 гол зориулалтаар ус ашигласан байна. Үүнд:

1. Баяжуулах үйлдвэрийн технологийн ус
2. Уурхайн зам усалгаа (чийгшүүлэлт)
3. Ажилчдын хотхоны унд-ахуйн ус

**<u>Технологийн хэрэглээний ус</u>**

Уурхайн элс баяжуулах үйлдвэрт баяжуулах технологийн шат дамжлагаас гарах эфель болон галь дахь ус нь өөрийн урсгалаар тунаах даланд хуримтлагдан тунана. Тунаах даланд тунасан ус нь мөн адил цэвэршүүлэх даланруу өөрийн уурсгалаар орно. Мөн цэвэршүүлэх даланд ил уурхайгаас шүүрэх усыг татаж баяжуулах цехэд ашиглана. Технологийн тооцоогоор 1 $м^3$ элс угаахад 4 $м^3$ технологийн ус зарцуулна. Усан сангийн доор ус үл нэвтрүүлэх материалаар доторлон усан санг байгуулсан бөгөөд технологийн усны 80%-ийг дахин ашигладаг.

## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 2.1 Уурхайн талбайн үндсэн замуудыг хайрган хучилттай болгож, тоос босохоос сэргийлэх арга хэмжээ авах

2025 оны 04 дүгээр сараас 10 дугаар сарын хооронд уурхайн олборлолтын талбай, карьерүүдийн зам дагуу, мөн уурхайгаас амралтын байр хүртэлх замд хайрга дэвсэж нийт 980$м^2$ талбайг хайрган хучилттай болгосон. Ухайн бүсэд олон салаа зам үүсгэхгүй, хөрсний элэгдэл эвдрэлээс урьдчилан сэргийлж ажиллаж байна. Тоосжилтыг багасгах зорилгоор усалгааг тогтмол хийж байна.








Тухайлбал овоолгыг усалж түрж, тоосжилтыг дарах усалгааг тогтмол хийж, нягтаршуулах зэрэг ажлыг техник тоног төхөөрөмжийн хүчийг ашиглан тогтмол хийж гүйцэтгэж байна.







### 2.2 Шатах тослох материалын агуулахыг эргэн тойрныг хатуу хучилттай болгох

Шатах тослох материалын агуулахын эргэн тойрны хатуу хучилттай ажлын талбайд хайрга, дэвсэж талбайг засах ажлыг хийсэн. Гэрээний дагуу ажлыг хийж гүйцэтгэхээр хоёр компани тохиролцсон. 2021 оны 08 дугаар сарын 09-ны өдөр “Хан Алтай Ресурс” ХХК-ны туслан гүйцэтгэгч “Макс Өргөө” ХХК-ний захирал Т. Түмэн-Өлзийтэй гэрээг байгуулж хатуу хучилттай болгох ажлыг хийхээр тохирсон. Уг компаний ажлын ачаалал болон цаг агаарын нөхцөл байдлаас болоод түр хойшлогдсон.









БАТЛАВ.
ЕСӨНБУЛАГ СУМЫН
ЗАСАГ ДАРГА Д.ЧИНЗОРИГ

**ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ**

2021 оны 08 сарын 09 дугаар 04 Алтай хот

Газрын хэвлийн тухай хуулийн 8 дугаар зүйл,Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 8.8 дугаар заалтыг үндэслэн нэг талаас Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын БОХУБ Н.Оюунцэцэг,Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглагчийг төлөөлж 5046696 регистртэй Макс өргөө ХХК-ий гүйцэтгэх захирал Т.Түмэн-Өлзий нар түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглах талаар харилцан тохиролцон энэхүү гэрээ (цаашид "Гэрээ " гэх)-г байгуулав.

**Нэг. Ерөнхий зүйл**

Наран багийн Ямаан усны аманд үйл ажиллагаа явуулж байгаа Болд гэнт болд ХХК-нь нийгмийн хариуцлагын хүрээнд 20000 м3 шламыг барилгын бетон зуурмагийн бүтээгдэхүүн гаргах зориулалтаар Макс-Өргөө ХХК-д нийлүүлнэ.

1.2.Түгээмэл тархацтай ашигт малтмал болох шламыг ашиглах талаар сум (дүүрэг)-ын Засаг дарга, Макс Өргөө ХХК-ний захирал Түмэн-Өлзий нарын хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

**Хоёр. Сум, дүүргийн Засаг даргын эрх, үүрэг**

2.1. Сум, дүүргийн Засаг дарга дараах эрх үүрэгтэй. Үүнд:

2.1.1. Түгээмэл тархацтай ашигт малтмал болох шламыг ашиглах газрыг зааж өгөх

2.1.2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газрын ашиглалтад заавар зөвлөгөө өгөх

2.1.3.Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийг төсөвт төвлөрүүлэх

2.1.4. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах

2.1.5.Гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд үйл ажиллагааг зогсоож, гэрээг цуцлах

2.1.6.Хүн, мал, байгаль орчинд сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулсан тохиолдолд үйл ажиллагааг зогсоох

2.1.7 "Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм"-ийг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих

**Гурав. Ашиглагчийн эрх, үүрэг**

3.1.Ашиглагч дараах эрх үүрэгтэй. Үүнд:

3.1.1.Ашиглагч нь гэрээнд заагдсан талбайн хил, хязгаарын дотор үйл ажиллагаа явуулах





**Шатах тослох материал алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж урьдчилан сэргийлэх**

Уурхайн автозасвар болон автозогсоолын хэсэгт шатах тослох материал асгаралтаас урьдчилсан сэргийлэх Монголд үйлдвэрлэсэн багцийг авч 1-ыг тавилаа.



## 2.3 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

2025 онд нийт **3.0 га** талбайд олборлолтын ажил явуулсан. Үйл ажиллагаа сайн явж чадаагүй тул техникийн нөхөн сэргээлт хийгээгүй. 2026 онд хийнэ.



## 2.4 Уурхайн  үйл ажиллагаанаас ургамлан бүрхэвч доройтох

“Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт хадгалалт” MNS 6916:2008 стандратын дагуу хөрсийг 03см-05см өнгөн хөрсийг техникийн тусламжтай хуулж шинэ шимт хөрсний овоолго үүсгэсэн. Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө 63180м3 үндсэн хөрс, 4883м3 шимт хөрсийг хуулан авч ил уурхайн хүрээг дагуулан байршуулж тусгайлан зассан овоолго үүсгэн техникийн шаардлага ханган ажилласан





## 2.5 Уурхайн ажилчид хууль бусаар амьтан агнах үйлдэл гаргах

2025 оны 04 дүгээр сараас  11 дүгээр сар хүртэл уурхайн замын маршрутыг дотоодод  дагаж мөрдөх журам гарган мөрдлөг болгон ажиллаж байна. Баталсан зам дагуу явах, олон салаа зам үүсгэхгүй байх тал дээр уурхайн бүх ажилчдад сургалтыг зохион байгуулсан.  Нийт 32 хүн оролцсон.

Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хариуцсан ажилтан, инженер техникийн ажилтан нар уурхайд олон салаа зам үүсгэхгүй байх, хөрсний элэгдэл эвдрэлээс урьдчилан сэргийлэх хяналтыг тавьж ажиллаж байна.

2025 оны 11 дүгээр сарын байдлаар Уурхайн бүсэд нийт 8 ширхэг тэмдэг, тэмдэглэл байрлуулсан байгаа.






## 2.5 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ Төслийн нутаг дэвсгэрийн ойр орчинд амьдарч буй зэрлэг ан амьтдыг хамгаалах сургалт зохион байгуулах

Төслийн нутаг дэвсгэрийн ойр орчинд Тарвага, Янгир Ирвэс, Чоно, Үнэг, Хярас, Хойлог, Хахилаг зэрэг зэрлэг ан амьтан, жигүүртэн шувууд үе үе цөөн тоогоор ажиглагддаг, усны эх үүсвэрийн хувьд хомс байдаг.

Уурхайн нийт ажилчид болон ойр орчмын ар иргэдэд зэрлэг ан амьтдыг хайрлаж хамгаалах талаар анхан шатны мэдлэгийг өгч зурагаар баримтжуулан ажилласан. Сургалтанд нийт 32 хүн хамрагдсан.










## 2.6 ЦЦАШ-ыг шувуу мөргөх, тогонд цохиулах











# 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## 3.1 Уурхайн олборлолтонд өртөж байгаа гадаад болон дотоод овоолгод техникийн нөхөн сэргээлт хийх

2018 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байгаа ашиглалтын талбай нь цаг агаарын нөхцөл байдал, гэнэтийн шар усны үерээр эвдэгдсэн талбайд гадаад болон дотоод овоолгод техникийн нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулж хийсэн.

Уурхайн үйл ажиллагааны эвдэрлээс үүссэн газрыг дотоод хөрөнгө нөөц бололцоогоор уурхай дотороо техникийн нөхөн сэргээлтийн ажил хийж ажиллаа.









## 3.2 Тухайн бүс нутагт уурхайн болон түүний дэд бүтцийн байгууламжуудтай холбогдон бий болсон газрын эвдэрлүүдийг багасгах

Тухайн бүс нутагт уурхайн болон түүний дэд бүтцийн байгууламжуудтай холбогдон бий болсон газрын эвдрэл одоогоор гараагүй бөгөөд тухай бүрт нь эвдрэл нөлөөлийг арилгах, багасгах арга хэмжээг авч ажиллана.

Овоолго хаягдлын байгууламжуудыг бүтцийн хувьд тогтвортой байлгах зорилгоор нягтаршуулан салихаар тархаж орчин тойрондоо хөрс эвдрэл үүсгэн ургамлан нөмрөгийг тоосжуулуулан ургалтанд үзүүлэх нөлөөллөөс сэргийлэх арга хэмжээг тухай бүр авч ажиллаж байна

## 3.3 Биологийн олон байдлыг дүйцүүлэн хамгаалах болон Тэрбум мод тарих аянд нэгдэж мод тарих

Дүйцүүлэн хамгаалах болон Мод тарих ажлын хүрээнд 17.5 сая төгрөгийг орон нутагт өгсөн. Төлбөрийн баримтыг хавсаргав.



Худалдаа Хөгжлийн Банк Огноо: 2025.10.13 22:42:37

Шилжүүлгийн мэдээлэл

Журналын №: 286303756

Системийн огноо: 2025.10.13

Нэр: ДАГВА ДУНГААМАА

| | | | Дүн | Ханш |
|---|---|---|---|---|
| Илгээгч | Дансны дугаар: 474046623 | Нэр: ДАГВА ДУНГААМАА | 17,500,000.00 MNT | 1.00 |
| / арван долоон сая таван зуун мянган төгрөг / | | | | |
| Хүлээн авагч | Банкны дугаар: 34<br>Дансны дугаар: MN860034241600094252 | Банкны нэр: Төрийн банк<br>Нэр: ЭРДЭНЭСУВД МӨНХӨӨ | 17,500,000.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга:
ЕВ -БолдгрантболдХХК БО ны нөхөн сэргээх модны төлбөр

Танд баярлалаа

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан

## 3.4 Биологийн нөхөн сэргээлт- шимт хөрс болон Ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Уурхайн үйл ажиллагаа тогтмол явагдаж байгаа талбайг хамгаалалт хийн, хөндөгдөөгүй ургамалжилт болон дахин ургамалжсан газруудад усалгаа хийх

Уурхайн үйл ажиллагаа тогтмол явагдаж байгаа талбайг тойруулан хамгаалалтын бүс байгуулан далан босгож олборолт хийгээгүй газрын хөрсний элэгдэл эвдрэлийг гаргахгүй тал дээр сургалт зохион байгуулж инженер техникийн ажилчид хяналт тавьж ажиллаж байна.

Төлөвлөгний дагуу үйл ажиллагаагаа явуулсан үед техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийж нутгийн унаган ургамлыг тарималжуулан талбай тусгаарлан туршилт хийж тойруулан хашаалж, хөндөгдөөгүй ургамалжилт болон дахин ургамалжсан газруудад мал, амьтан бэлчээрлэхээс сэргийлэх ажлыг зохион байгуулахаар бэлтгэл ажил хийгдэж байна. Уурхайн ашиглалтын хугацааны туршид тасралтгүй явуулах зорилгоор хөрсний ялзмагийг хамгаалж хадгалж үлдэх суурь алхам болох нягтаршуулах усалгааг тогтмол хийж байна.





## 4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

### 4.1 Хог хаягдал хадгалах зориулалтын цэгт хогийн савыг 3-аас доошгүй Түр хадгалах хог төрлөөр ялгаж хаях, хаягдлын цэг хогийн гэрээг сунгуулах, хогны төлбөр төлөх

Уурхайгаас гарах хатуу, шингэн, аюултай хог хаягдалын хэмжээг ашиглалтын эхний жилээс хаалт хийх хүртэл тооцоолох, уурхайд тохирох дэвшилтэт технологи, үнэ ханш зэргийг судлах ажлыг зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа ажилтан гүйцэтгэж байгаа бөгөөд хатуу хог хаягдлыг ялгах, зайлуулах, дахин боловсруулалтад оруулах талаар менежментийн төлөвлөгөөг судалгаанд суурилсан боловсруулж хэрэгжилтийг хангана ажиллаж байна. Хог хаягдал хадгалах хогийн цэгийг 3-аас доошгүй байгуулж ялган хаях цэгт хог хаягдлыг ангилан ялгуулж хаясан.




*Хогийн цэгийг засаж сайжруулж байгаа байдал*






### 4.2 Хог хаягдлыг тээвэрлэж, зайлуулж байх

Уурхайгаас гарсан хог хаягдлыг түр цэгт хадгалан Есөнбулаг сумын тохижилт үйлчилгээний газртай гэрээ байгуулан ачуулж төвлөрсөн хогын цэгт хүргэн ажиллаж байна









### 4.3 Аюултай хог хаягдлын хор, аюулын талаарх лавлах мэдээлэл, тэдгээрийг тээвэрлэх болон хадгалах явцад гарч болзошгүй ослын үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж сургалт зохион байгуулах

2025 оны тухайд шатах тослох 180 литр материалыг Улаанбаатар хотоос 1 удаа тээвэрлэн авчирсан бөгөөд ачих, буулгах, хадгалах үеийн анхан шатны заавар зөвлөмжийг Хөдөлмөрийн аюулгүй байдлын ажилтан нь  жолооч ачигч нарт зааварчилгааг өгч осол аюулгүй байдлыг бүрэн хангаж ажилласан.

“Аюултай хог хаягдлыг хор, аюул, тээвэрлэх болон хадгалах явцад гарч болзошгүй ослын талаарх сургалтыг”  уурхайн бүх ажилтанд сургалтыг зохион байгуулсан нийт **32 хүн** хамрагдсан.

### 4.4 Аюултай хог хаягдалтай ажиллагдсыг арьс, нүд болон амьсгал хамгаалах зориулалт бүхий, стандартын шаардлага хангасан хамгаалах хэрэгслээр хангах

Аюултай хог хаягдалтай харьцах үед ажиллагдсыг арьс, нүд болон амьсгал хамгаалах зориулалт бүхий, стандартын шаардлага хангасан хамгаалах хэрэгсэл ажлын **хувцас бээлий, маск, нүдний шил, баг** зэргээр тогтмол ханган 1 хүнд 360.0 мянган төгрөг зарцуулсан байна










### 4.5 Аюултай хог хаягдал устган зайлуулах мэргэжлийн байгууллагад гэрээ хийн хүлээлгэн өгөх

Уурхайгаас гарсан хог хаягдлыг түр цэгт хадгалан Есөнбулаг сумын тохижилт үйлчилгээний газртай гэрээ байгуулан ачуулж төвлөрсөн хогын цэгт хүргэн ажиллаж байна. Ашигласан тос маслыг улаанбаатар хот руу тээвэрлэж байна. Шатах тослох материал дахин боловсруулах “Алтан оршихуй групп” ХХК-тай гэрээтэй ажилладаг.





## 5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Тухайн төслийн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

## 6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

2025 оны уурхайн үйл ажиллагааны явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвор олдоогүй болно. Цаашид түүх соёлын дурсгалт зүйлс, олдвор олдсон тохиолдолд уурхайн үйл ажиллагаа түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

# 7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## 7.1 Гал унтраах багаж хэрэгсэл байрлуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах

Уурхайн бүсэд шинээр ажилд орж байгаа бүх ажилчидад “Хөдөлмөрийн аюулгүй байдал”, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”, “Гал унтаах, багаж хэрэгсэлтэй хэрхэн харьцах”, “Гашигаас урьдчилан сэргийлэх” сургалтыг зохион байгуулж, батгалгаажуулан шалгалт авч тэнцсэн тохиолдол ажилд гаргах ажлыг зохион байгуулж ажилласан. Сургалтанд нийт 58 хүн хамрагдсан. Уурхайн бүсэд цугларах цэг 1 ширхэг, Гал унтраагуурын иж бүрдэл ком 1 ширхэг, Уурхайн кемпийн орчинд гал унтраагуур 14 ширхэгийг байрлуулсан, Уурхайн бүх техникүүдэд галын хорыг байрлуулсан нийт 17 ширхэг галын хорыг шинээр байрлуулсан.








### 7.2 Эрүүл мэндийн үзлэгт хамруулах

2025 онд орсон эрүүл мэндийн үзлэгт хамрагдаагүй ажилчидыг Говь-Алтай аймгмйн нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт хамруулан ЭХО, бусад нарийн шинжилгээ өгсөн төлбөр болох 1.620.0 төгрөгний төлбөрийг хариуцан ажилласан бөгөөд ажилчдын шинжилгээний хариугаар ажилчид эрүүл мэндийн хувьд ямар нэгэн өөрчлөлтөнд ороогүй байна





### 7.3 Болзошгүй аюул ослын үед хэрэглэх бүрэн ажиллагаатай гал унтраагуур, анхан шатны багаж хэрэгсэлтэй байх

Болзошгүй аюул ослын үед хэрэглэх бүрэн ажиллагаатай гал унтраагуур галын хор 15 ширхэгийг амралтын хотхон болон машин механизм засварын талбайд байрлуулсан. Мөн гал унтраагуур галын булан, багаж хэрэгслийг суурьлуулсан. Амрах хотхонд утаа мэдрэгчийг байрлуулсан. Галын буланд Хүрз тогтоогчтой элсны хайрцаг 1 ширхэг, галын хувин 1 ширхэг, галын дэгээ 1 ширхэг, галын жоотуутай модон сүх 1 ширхэг, галын хүрз 1 ширхэг, галын цохиур 1 ширхэг, галд тэсвэртэй бээлий 1 ширхэг, ABC-12 кг галын хор 3 ширхэг, галын хөрөө, галын сараалжин самбар сараа 1 ширхэг зэрэг анхан шатны багаж хэрэгсэлийг хийсэн












## 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн төлөвлөгөө

**Агаарын чанар**

Говь-Алтай аймгийн Ус Цаг Уур Орчны шинжилгээний төвтэй "Ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулж агаарын бохирдлын (NO2, SO2, CO,) Агаарын тоосны ( PM10, PM2.5) шинжилгээг олборлолтын талбайд 1 цэгээс 30 минутын давтамжтай 3 удаа шинжилгээг авсан. Агаарын бохирдлын (NO2, SO2, CO,) Агаарын тоосны ( PM10, PM2.5) шинжилгээг Говь-Алтай аймгийн УЦУОШ төвийн БОШЛ-ийн инженер Ц. Болормаа, "Болдгянтболд" ХХК-ны Байгаль орчны мэргэжилтэн Р. Батгэрэл нар шинжилгээний дээжийг авч хамтран ажилласан. Агаарын чанарын үндсэн үзүүлэлт болох Азотын давхар исэл бохирдлын (NO2),Хүхэрлэг хий (SO2), Агаарын тоосны ( PM10, PM2.5) нь MNS4585;2016 стандартаас давж бохирдоогүй байна.



БАТЛАВ:
УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГА
Н.АЛТАНТУЯА

БАТЛАВ:
"БОЛД ГЯНТ БОЛД " ХХК-НИЙ УУРХАЙН ДАРГА
Х.ОЛОНБААТАР

**АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

2021 оны 10-р сарын 29-ний өдөр № 03 Алтай хот

Нэг талаас ***[ "БОЛД ГЯНТ БОЛД" ХХК ]*** (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас ***[Говь-Алтай аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв]*** (цаашид "гүйцэтгэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2021 оны 10-р сарын 29-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

**Нэг. Гэрээний ерөнхий нөхцөл**

1.1 Иргэний хууль, бусад хууль тогтоомжийн дагуу ажил гүйцэтгэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

1.2 Захиалагч нь ***["БОЛД ГЯНТ БОЛД" ХХК-ний Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Наран багийн нутагт байрлах ашиглалт явуулж буй талбайн орчноос агаар, хөрс, усны хяналт шинжилгээ хийх"]***-г (цаашид "ажил" гэх) *[474900 /Дөрвөн зуун далан дөрвөн мянга есөн зуун төгрөг/]* (цаашид "гэрээний үнэ" гэх) гүйцэтгэхийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь шинжилгээний төлбөр болно.

1.3 Гүйцэтгэгч нь "БОЛД ГЯНТ БОЛД" ХХК-ны ашиглалт явуулж буй талбайн орчноос агаар, хөрс, усны хяналт хийх шинжилгээг хавсралтад тусгасан үзүүлэлтүүдийн дагуу 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор гүйцэтгэж шинжилгээний дүнг хүлээлгэж өгнө.

1.4 Захиалагч нь шинжилгээний дээж авснаас 7 хоногийн дотор гүйцэтгэгчид өгөх төлбөрийг /474900₮/ гүйцэтгэгчийн Төрийн сан банк Га.ЦУОШАлба 100050013015/ тоот харилцах дансанд шилжүүлэх журмаар төлнө.

1.5 Гүйцэтгэгч нь шинжилгээний төлбөр дансанд орсноос хойш 14 хоногийн хугацаанд багтаж шилжилгээний дүнг захиалагчид цахим болон баталгаажуулсан хэлбэрээр хүлээлгэж өгнө.

**Хоёр. Талуудын эрх, үүрэг**

**2.1 Захиалагчийн эрх үүрэг**
2.1.1 Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлийг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээнэ.

2.1.2 Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

1



2.1.3 Захиалагч гүйцэтгэгчээс тус ажлын хүрээнд үнэн, зөв бүрэн мэдээлэл гаргуулан авах эрхтэй.

2.1.4. Захиалагч нь шинжилгээний дээж авах мэргэжилтнийг унаагаар ханган томилолтын зардлыг олгоно. Гүйцэтгэгч талын 1 ажилчинд олгох томилолтын зардал хоногийн 35,000 (Гучин таван мянга) төгрөг байна. Унаа болон томилолтын зардал шинжилгээний төлбөрт ороогүй болно.

**2.2 Гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

2.2.1 Гүйцэтгэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэх хариуцлагыг хүлээж байна.

2.2.2 Захиалагчаас гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй .

**Гурав. Бусад зүйл**

3.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох ба гэрээний үүргийн гүйцэтгэл бүрэн биелэгдсэнээр гэрээ дуусгавар болно.

3.2 Энэхүү гэрээний хавсралт нь гэрээний адил хүчин төгөлдөр байна.

3.2 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэн талуудад хадгалагдах бөгөөд эдгээр нь хууль зүйн хувьд адил хүчинтэй.

3.3 Энэхүү гэрээ нь Монгол улсын хууль тогтоомжийг үндэслэн хийгдсэн бөгөөд түүний дагуу зохицуулагдана. Хуульд өөрөөр заагаагүй бол гэрээний зүйл заалтыг нэн тэргүүнд баримтална.

3.4 Энэхүү гэрээтэй холбоотой саналын зөрүүтэй асуудлыг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэх ба ийнхүү шийдвэрт хүрээгүй нөхцөлд хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

3.5 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

"БОЛД ГЯНТ БОЛД " ХХК-ний Байгаль орчны мэргэжилтэн
Утас: 88228079
Гарын үсэг:
........................../ Р.БАТГЭРЭЛ /

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Говь-Алтай аймгийн УЦУОШТөв
Утас: 88874028, 70484093
Гарын үсэг:
ЦУОТХ-ийн дарга
................../Т.ДЭЛГЭРМАА/
БОШЛ-ын инженер
................. / Ц.БОЛОРМАА /

2

*Ажил гүйцэтгүүлэх гэрээ*

| | 2020 он | | 2021 он | |
|---|---|---|---|---|
| Агаар бохирдуулагч бодис | $SO_2$ мг/м$^3$ | $NO_2$ мг/м$^3$ | $SO_2$ мг/м$^3$ | $NO_2$ мг/м$^3$ |
| Дундаж | *0.035* | *0.022* | *0.010* | *0.022* |
| Хүлцэх хэмжээ | *0.450* | *0.200* | *0.450* | *0.085* |

*Агаарын шинжилгээ авч байгаа байдал болон шинжилгээний хариу*










**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**
**БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН**
**ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com

MNAS
БАЙГАЛЬ

**СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он/№ : 2025/А-385-386
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас "Болдгянтболд" ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл : 2 агаар, 2 дуу чимээ
Сорьц авсан огноо : 2025.05.22
Сорьцын тодорхойлолт : Говь-алтай аймаг, Есөнбулаг төв, Ухашны салхин дор
Төгрөг Баян Хангай ХХК
Шинжилгээний аргын стандарт Алтны шороон орд
: MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021
Шинжилсэн огноо MNS 6768:2019, САЗ А07-2016
Хуудасны тоо : 2025.06.02
Үр дүн : : 1/1

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий | Азотын давхар исэл | Нийт тоос /TSP/ | Дуу чимээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мг/м3 | | | ДБА |
| 1 | Гадна талбай | 25/05/22 | 11:30 | 0.012 | 0.048 | 0.530 | 48 |
| **Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)** | | | | **0.450** | **0.200** | **0.500** | **60** |
| 2 | Уурхай дотор орчин | 25/05/22 | 12:00 | 0.014 | 0.028 | 0.560 | 66 |
| **Хөдөлмөрийн аюулгүй байдал,эрүүл мэнд.Ажлын байрны орчин.Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015** | | | | **2** | **2** | **2** | **-** |
| **Хөдөлмөрийн аюулгүй байдал,эрүүл мэнд.Шуугианы норм.Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 6768:2019** | | | | | | | **85** |

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч : Э.Оюунтуяа
Хянаж баталгаажуулсан ахлах шинжээч: Д.Тумэндэлгэр







| *Усан бууны хэсэг* | *2020* PM10 мг/м3 | 2020 PM2,5 мг/м3 | *2021* PM10 мг/м3 | 2021PM2,5 мг/м3 |
|---|---|---|---|---|
| Дундаж | ***0.014*** | ***0.018*** | ***0.013*** | ***0.019*** |
| Их | *0.103* | *0.021* | *0.015* | *0.012* |
| Бага | *0.021* | *0.011* | *0.005* | *0.015* |
| **MNS 4585:2016** | ***0.100*** | ***0.50*** | ***0.100*** | ***0.50*** |

| *Улын карьерийн хэсэг* | *2020* PM10 мг/м3 | 2020 PM2,5 мг/м3 | *2021* PM10 мг/м3 | 2021PM2,5 мг/м3 |
|---|---|---|---|---|
| Дундаж | **0.011** | **0.09** | ***0.010*** | ***0.010*** |
| Их | *0.086* | *0.021* | *0.093* | *0.025* |
| Бага | *0.006* | *0.004* | *0.007* | *0.006* |
| **MNS 4585:2016** | ***0.100*** | ***0.50*** | ***0.100*** | ***0.50*** |



**БОШЛабораторийн тоос, тоосонцорын шинжилгээний дүн**

Дугаар он/№ : 2021/ 3
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : УЦУОШТөвийн БОШЛ
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : БОШЛ-ийн инженер Ц.Болормаа
Дээжийн тоо, төрөл : 2.Тоос
Хүлээн авсан огноо : 2021.11.02
Дээжийн тодорхойлолт : "Болд Гянт болд"- ХХК /Усан бууны хэсэг/
Шинжилсэн огноо : 2021.11.02
Хуудасны тоо : 1/1
Үр дүн

| Агаар бохирдуулагч бодис | PM10 мг/м3 | PM2,5 мг/м3 |
|---|---|---|
| **Дундаж** | **0.013** | **0.019** |
| Их | 0.015 | 0.012 |
| Бага | 0.005 | 0.015 |
| MNS 4585:2016 | 0.100 | 0.50 |

Дугаар он/№ : 2021/ 3
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : УЦУОШТөвийн БОШЛ
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : БОШЛ-ийн инженер Ц.Болормаа
Дээжийн тоо, төрөл : 2.Тоос
Хүлээн авсан огноо : 2021.11.02
Дээжийн тодорхойлолт : "Болд Гянт болд"- ХХК /Уулын карьеар/
Шинжилсэн огноо : 2021.11.02
Хуудасны тоо : 1/1
Үр дүн

| Агаар бохирдуулагч бодис | PM10 мг/м3 | PM2,5 мг/м3 |
|---|---|---|
| **Дундаж** | **0.010** | **0.010** |
| Их | 0.093 | 0.025 |
| Бага | 0.007 | 0.006 |
| MNS 4585:2016 | 0.100 | 0.50 |

Баталгаажуулсан:
УЦУОШТ-ийн дарга ............ Н.Алтантуяа
Хянасан:
ЦУОТХэлтсийн дарга ............ Т.Дэлгэрмаа
Шинжилгээ гүйцэтгэсэн:
БОШЛ-ийн инженер ............ Ц.Болормаа



**БОШЛабораторийн агаарын шинжилгээний дүн**

Дугаар он / № : 2020 / 8
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : УЦУОШ Төвийн БОШЛ
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : БОШЛ-ийн инженер Ц.Болормаа
Дээжийн тоо, төрөл : 3, агаар
Хүлээн авсан огноо : 2020.10.30
Дээжийн тодорхойлолт : "Болд гянт болд" ХХК
Шинжилсэн огноо : 2020.10.30
Хуудасны тоо : 1/1

| | Өдөр | Цаг | Даралт, мм | Температур, °C | салхи зүг, градус | хурд, м/с | Чийг, % | Цаг агаарын байдал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| "Болд гянт болд" ХХК | 2020.10.30 | 8 | 575,9 | 0,8 | БХ | 14 | 70 | үзэгдэлгүй |
| | | 14 | 575,9 | 3,8 | БХ | 5 | 59 | үзэгдэлгүй |
| | | 20 | 575,9 | 1,2 | БХ | 3 | 56 | үзэгдэлгүй |



| Цаг | $SO_2$ мг/м3 | $NO_2$ мг/м3 |
|---|---|---|
| 8 | 0.008 | 0.012 |
| 14 | 0.006 | 0.024 |
| 20 | 0.064 | 0.032 |
| Дундаж | 0.035 | 0.022 |

| Агаар бохирдуулагч бодис | $SO_2$ мг/м3 | $NO_2$ мг/м3 |
|---|---|---|
| MNS4585:2016 | 0.450 | 0.200 |
| Дундаж | 0.035 | 0.022 |

Агаарын чанарын үндсэн үзүүлэлт болох Азотын давхар исэл ($NO_2$) ,Хүхэрлэг хий ( $SO_2$ ) , нь MNS4585:2016 стандартаас давж бохирдоогүй байна.

Баталгаажуулсан: УЦУОШТ-ийн дарга Н.Алтантуяа
Хянасан :БОШЛ-ийн эрхлэгч Д.Сарантуяа
Шинжилгээ гүйцэтгэсэн: БОШЛ-ийн инженер Ц.Болормаа

## Усны хяналт шинжилгээ

2025 оны 09 дугаар сарын 22-ны өдөр Хөрсний дээж авч “Нарт шүүн консалтинг” ХХК лабораторит хүргүүлсэн. Итгэмжлэгдсэн лабораторид 25 үзүүлэлтээр ундны усны ерөнхий химі, хүндметалл, эрүүл ахуйг шинжилгээнд хамруулсан. стандартаас давж бохирдоогүй байна.

Усан сангийн ус / карьерийн ус, үерийн усны / хувьд химийн бүрэлдэхүүнээрэй сульфатын ангийн, магнийн бүлгийн 2-р төрлийн чанарын хувьд хүрэлцэх хэмжээнээс жаахан давсан буюу дунд зэргийн эрдэсжилттэй, хатуулаг өндөртэй ус байна гэж тодорхойлжээ.

Цахир булгийн ус Эрүүл ахуйн шаардлага чанар аюулгүй байдлын үнэлгээ: MNS 900:2005 болон бусад стандартуудтай харицуулан үзхэд pH-усан орчин хэвийн, ерөнхий хатуулаг стандарт хэмжээнээс бага, бусад 25 үзүүлэлт стандартад нийцэж байгаа бөгөөд хүн амын ундандаа зөөлрүүлэх шаардлаггүйгээр хэрэглэх шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан.



“НАРТ ШҮҮН КОНСАЛТИНГ” ХХК
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

№ 25/09-03/-1

Аргын стандарт: MNS1097:1970

| Катион | 1 дм³ | | | Анион | 1 дм³ | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мг/л | мг-экв/л | мг-экв/% | | мг/л | мг-экв/л | мг-экв/% |
| $Ca^{++}$ | 66.00 | 3.29 | 74.80 | $CO_3^{--}$ | 0.00 | 0.00 | 0.00 |
| $Mg^{++}$ | 10.00 | 0.82 | 18.69 | $HCO_3^-$ | 156.00 | 2.56 | 58.07 |
| Fe | 0.00 | 0.00 | 0.00 | $Cl^-$ | 36.00 | 1.02 | 23.07 |
| $K^+$ | 1.00 | 0.03 | 0.58 | $SO_4^{--}$ | 36.00 | 0.75 | 17.04 |
| $Na^+$ | 6.00 | 0.26 | 5.93 | $NO_3^-$ | 5.00 | 0.08 | 1.83 |
| Дүн | 83.00 | 4.40 | 100.00 | Дүн | 233.00 | 4.40 | 100.00 |

316 мг/л
238 мг/л
Хуурай үлдэгдэл, мг/л: 162 ppm
Ерөнхий хатуулаг: 4.11 мг-экв/л
Урвалын орчин: pH- 6.96
EC -0.472 ds/m
TDS: 199 ppm

$$M(0.32) = \frac{HCO3\ 58\ [Cl\ 23\ SO4\ 17]}{Ca\ 75\ [Mg\ 19\ Na\ 6]}$$

1. УСНЫ ЭРҮҮЛ АХУЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН, 1 МЛ УСАНД



2. УСНЫ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| Ус | Дээж авсан гүн, см | Усны хүнд металлын агууламж, мг/л | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Cr | Pb | Cd | Zn | Cu | Ni |
| Гүний худаг | - | 0.0 | 0.0 | 0.0 | 0.033 | 0.014 | 0.0 |
| Зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 4586:1998 | | | | | | | |
| Хүлцэх агууламж | | 0.01 | 0.01 | 0.00 | 0.01 | 0.01 | 0.01 |

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД : (Эрүүл Ахуйн Шинжилгээний Стандарт MNS 5668:2006, Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 MNS ISO 8288:1999, Атом шингээлтийн спектрометрээр.)

ЗАДЛАН ШИНЖЛЭГЧ: С.НЯМДАШ MSc
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: Г.СОЛОНГО Ph.D, Дэд проф.





## Хөрсний бохирдол

2025 оны 09 дугаар сарын 22-ны өдөр Хөрсний дээж авч "Нарт шүүн консалтинг" ХХК лабораторит хүргүүлсэн. Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид 19 үзүүлэлтээр ерөнхий химиi, хүндметалл, эрүүл ахуйг шинжилгээнд хамруулсан. Стандартаас давж бохирдоогүй байна.

Хөрсний механик бүрэлдэхүүний хувьд: Овоолго орчимд 0.25-0.05 мм –т хамгийн их 49.80 байсан бол 0.001мм-т хамгийн бага буюу 3.8 байна. Карьер орчимд 1-0.25 мм –т хамгийн их 45.2 байсан бол 0.005-0.001мм- т хамгийн бага буюу 5.6 байна. Үүнээс хархад хөрсний механик бүрэлдэхүүн овоолго дээр ширхэгүүд багасаж байна. Хүнд металлын хувьд 6 төрлийн үзүүлэлтээс овоолго орчмоос Никель 29 мг/кг илэрсэнээс бусад элмэнтүүд илээгүй бол карьер дээр Никель 27 мг/кг, Зэс 89 мг/кг, Цайр 1.80 мг/кг Хром 61,4 мг/кг илэрсэн Карьер дээр Кадми, Хар тугалга 2 оос бусад элемент 87.9-23.5мг/кг илэрсэн нь цаашид уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр хөрсөнд хүнд металлийн агууламж өсөх хандлагатай байгааг харгалзан үзэж саармагжуулах арга хэмжээг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тодорхой тусган ажиллах шаардлагатай.






"НАРТ ШҮҮН КОНСАЛТИНГ" ХХК
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

№ 25/09-03/-9

Захиалагч: "Белдгинтболд" ХХК
Сорьц авсан огноо: 2025 оны 09 сар 22 өдөр
Шинжилгээ хийсэн огноо: 09 сарын 29

1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| № | Дээж авсан гүн, см | pH | Давс, % | ЦДЧ, ds/m | Ялзмаг, % | $CaCO_3$, % | $NO_3$, мг/100г | Солилцох суурууд, мг-экв/100 г | | Шим тэжээлийн элементүүд, мг/100г | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | $Ca^{+2}$ | $Mg^{+2}$ | $P_2O_5$ | $K_2O$ |
| Зүсэлт 1 | | | | | | | | | | | |
| 1 | 0-30 | 7.80 | 0.060 | 0.142 | 1.98 | 2.28 | 0.53 | 14 | 12 | 4.3 | 10 |
| Зүсэлт 2 | | | | | | | | | | | |
| 2 | 0-20 | 7.88 | 0.065 | 0.154 | 1.84 | 1.14 | 0.58 | 13 | 10 | 3.9 | 14 |
| Зүсэлт 3 | | | | | | | | | | | |
| 3 | 0-20 | 7.97 | 0.056 | 0.133 | 2.08 | 0.96 | 0.49 | 14 | 9 | 4.2 | 14 |

2. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

| № | Дээж авсан гүн, см | Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| Зүсэлт 1 | | | | | | | | |
| 1 | 0-30 | 3.1 | 57.2 | 20.1 | 8.7 | 5.0 | 5.9 | 19.6 |
| Зүсэлт 2 | | | | | | | | |
| 2 | 0-20 | 3.7 | 58.0 | 18.2 | 10.6 | 4.1 | 5.4 | 20.1 |
| Зүсэлт 3 | | | | | | | | |
| 3 | 0-20 | 4.9 | 58.0 | 17.2 | [illegible] | 3.2 | 7.3 | 19.9 |

3. ХӨРСНИЙ ЭРҮҮЛ АХУЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН, ГР ХӨРСӨНД

| № | Дээжний дугаар | Нянгийн тоо | Гэдэсний савханцрын титр (E.coli) MNS 3297:2019 | | Анаэробууд (Cl.perfringens) MNS 3297:2019 | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Шинжилгээний хариу | Шинжилгээний хариу | Бохирдлын зэрэг | Шинжилгээний хариу | Бохирдлын зэрэг |
| 1 | Зүсэлт 1 | $7.1*10^3$ | ≥0.1 | 1 | ≥0.1 | 1 |

4. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| Дээж авсан газар, Газар зүйн байршил | Дээж авсан гүн, см | Cr | Pb | Cd | Zn | Cu | Ni |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг |
| Зүсэлт 1 | 0-30 | 52.2 | 19.3 | 0.0 | 9.5 | 10.0 | 3.4 |
| Зүсэлт 2 | 0-20 | 61.3 | 24.3 | 0.0 | 40.4 | 12.0 | 13.0 |
| Зүсэлт 3 | 0-20 | 46.2 | 21.8 | 0.0 | 5.7 | 10.3 | 9.5 |
| Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019 | | | | | | | |
| Элсэрхэг хөрс | | 60 | 50 | 1 | 100 | 60 | 60 |
| Шавранцар хөрс | | 100 | 70 | 1.5 | 150 | 80 | 100 |
| Шаварлаг хөрс | | 150 | 100 | 3 | 300 | 100 | 150 |

*Харгалзах түвшин   * Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарна

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД : (Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд MNS3310:1991, MNS ISO10390, Хөрсний механик бүрэлдэхүүн MNS6824:2020, Эрүүл Ахуйн Шинжилгээний Стандарт MNS 5367:2004, MNS6341:2012,Хүнд металлуудыг -хаан дарсанд атом шингээлтийн спектрометрээр MNS ISO 11466:2007)

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН: Х.УУГАНЦЭЦЭГ, С.НЯМДАШ

ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ Г.СОЛОНГО Ph.D, Дэд профессор

## 9.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Байгаль орчинд авч хэрэгжүүлсэн ажлыг орон нутгийн удирдлага болон иргэд нийтэд тайлагнах**

“Болд гянт болд ХХК”-д нь Есөнбулаг сумын Наран багын иргэдтэй Уурхайн үйл ажиллагаа болон байгаль орчинд авч хэрэгжүүлсэн ажил, орон нутагтай хамтран ажилласан ажлуудыг танилцуулж цаашид хийгдэх ажлын саналыг солилцсон. Хуралд Есөн булаг сумын Засаг дарга, Наран багын дарга, наран багын ард иргэд оролцсон нийт 63 хүн оролцсон. Нийт 6 ажлын санал ирсэнээр энэ онд хийгдэх боломжтой 3 ажлыг хийж гүйцэтгэсэн байна.





**Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон биелэлтийн тайланг хугацаандаа танилцуулах. Батлуулах**

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг жилийн эцсээр гаргаж холбогдох байгуулага болон орон нутагт хүргүүлсэн. Цахим болон цаасан хэлбэрээр холбогдох газруудад хүргүүлсэн

**Дүгнэлт**

Зүүн сайрын Дугуй нэртэй алтны шороон ордыг хувьд үйл ажиллагаа явуулсан энэ хугацаанд бэлтгэл ажлыг хангах үүднээс ил уурхай, хөрсний гадаад овоолго, технологийн ус болон хаягдлын далан, хаягдал нуурын далан баяжуулах үйлдвэрийн талбайн шимт хөрсийг хуулах, баяжуулах үйлдвэрийн талбайг байгуулах, угсрах зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн бөгөөд ТЭЗҮ-д тусгагдсаны дагуу бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадаагүй байна. 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор тухай бүрт нь өөрийн боломж, нөөцөд тулгуурлан зохион байгуулж нийт 22.000.00 сая төгрөг зарцуулхаар тусгаснаас 35.000.000 сая төгрөг зарцуулсан байна. Бусад үйл ажиллагаа явуулхад шаардагдах холбогдох зөвшөөрлийг гаргуулан гэрээ байгуулан, төлбөр мөнгийг цаг тухайд нь барагдуулж ажилласан бөгөөд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу хөрс, агаар, усны шинжилгээ хийхэд 6.400.000 төгрөг зарцуулагдсан. Шинжилгээний хариуг үндэслэн 2026 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулах болно. Мөн үйл ажиллагаан нь бүрэн жигдэрч ажиллахгүй багаа нь хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй байдлаас үүсэлтэй бөгөөд удирдлага зохион байгуулалтын хүрээнд гадаад хөрөнгө оруулалтыг татах, мэрэгжилтэй боловсон хүчнээр төслийн багийг бүрдүүлж ТЭЗҮ тусгагдсан хүчин чадлаар ажиллахад анхаарч 2026 оны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нарийвчилсан үнэлгээг үндэслэн оновцтой төлөвлөн хэрэгжилтийг бүрэн хангана ажиллан дүрэм журмын дагуу тайлагнах болно.